



**УВС АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ДҮНГЭЭС**





2023 ОН



Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 187 төсвийн шууд захирагч, 19 төвлөрүүлэн захирагч, 23 төрийн өмчит аж ахуйн нэгж, 3 тусгай сан, нийт 232 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 169 тайланд дүгнэлт гаргаж, 63 тайланг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан байдал



Аудитын дүгнэлт хүргүүлсэн 169 байгууллагаас 160 байгууллага "Өөрчлөлтгүй", 9 байгууллага "Хязгаарлалтай" дүгнэлт авсан байна.





Харьяа байгууллагуудад 1,130.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 970.2 сая төгрөгийн 20 алдааг залруулж, 7.3 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 58.7 сая төгрөгийн 5 зөрчил арилгах албан шаардлага хүргүүлж, 94.4 сая төгрөгийн 7 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа 970.2 сая төгрөг

Төлбөрийн акт 7.3 сая төгрөг

Албан шаардлага 58.7 сая төгрөг

Зөвлөмж 94.4 сая төгрөг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитын илрүүлэлт



Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 534.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 39.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 495.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Төлбөрийн акт 39.1 сая төгрөг

Зөвлөмж 495.5 сая төгрөг

Төсвийн төлөвлөлт

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг 46,809.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн зарцуулалт

Төсвийн ерөнхийлөн захирагч 2022 онд 20 хөтөлбөрийг санхүүжүүлэхдээ 42,162.4 сая төгрөгийг зарцуулсан байна.



АУДИТААР НИЙТЛЭГ ИЛЭРЧ БУЙ АЛДАА, ЗӨРЧЛҮҮД

АЛДАА, ЗӨРЧЛҮҮД

1

Цалин, нэмэгдэл, тэтгэмжийг алдаатай тооцоолсон, тушаал шийдвэргүйгээр олгосон, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад үр дүнгийн урамшуулал олгосон.

2

Анхан шатны баримтын бүрдэл дутуу орлого, зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгасан.

3

Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүй, авлага, өр төлбөр үүсгэсэн, үүссэн өр төлбөрийг бүртгэл тайланд тусгаагүй.

4

Төсөвт зохицуулалт хийлгүйгээр буюу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

5

Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивдэггүй.

6

Үндсэн хөрөнгө, бараа материалыг биетээр хүлээн аваагүй байхад бүртгэлд тусгасан, нярвын тайлан, нягтлан бодох бүртгэлд үлдэгдэл зөрүүтэй тайлагнадаг.